

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 7341 дүгээрт бүртгэв.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ БАЯННУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДЫН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 6 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 20

Цул-улаан

СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.22 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 64.6 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын IV дүгээр хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Сумын малчин, мал бүхий иргэдийн бэлчээр ашиглах, хамгаалах талаар нийтээр дагаж мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

2.Сумын малчин, мал бүхий иргэд, хуулийн этгээдээс нутаг бэлчээр ашиглах, хамгаалах, хадлангийн талбай ашиглах талаар нийтээр дагаж мөрдөх журмыг сурталчлан удирдлага зохион байгуулалтаар ханган хэрэгжүүлж ажиллахыг сумын засаг дарга /Н.Мөндигүл/-д үүрэг болгосугай.

3.Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг сумын ИТХ-ын ажлын албанд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж. ЕСКЕНДИР

*Баян-Өлгий аймаг Баяннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 20 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

БАЯННУУР СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1.Сумын малчид мал бүхий иргэд нь бэлчээрийн доройтлыг бууруулах, бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, ургамлын зүйл төрлийг нэмэгдүүлэх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангаж, бэлчээр ашиглалтын хуваарийг дагаж мөрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2.Нөөцөлсөн бэлчээр , тариалан, хадлангийн талбай өвөлжөө, намаржааны бүс нутагт мал оруулан гишгүүлэхгүй, чөлөөлсөн хугацаанаас түрүүлж бэлчээрлүүлэхгүй, зөвшөөрөлгүйгээр тус нутагт нүүдлүүлэхгүй байх, төв суурин болон тариалангийн, хадлангийн талбай өвөлжөөний бүс нутгийг бүрэн чөлөөлж, холбогдох хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх, зүй зохистой ашиглах талаар

Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид «бэлчээр ашиглалтын төлөвлөгөө « гэх) нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэсэн байна.

2.2.Бэлчээрийг улирлын хуваарьтайгаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг гаргасан байна.

2.3.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн байна.

2.4.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.5.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх болон бусад арга хэмжээнд мал эмнэлгийн ариун цэврийн дүрмийг мөрдөн дагаж биелүүлнэ.

2.6.Хадлан өвс бэлтгэхийн тулд ургацыг гүйцэт ургах болон үр боловсорсон үед бэлтгэх

Гурав. Бэлчээр ашиглалтын журмыг хэрэгжүүлэх ерөнхий арга хэмжээ:

Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг шийдвэр гаргаж хэрэгжилтийг зохион байгуулна.

/Зусланд 06-р сарын 20-нд нүүж бэлчээр, хадлангийн талбайг чөлөөлөх, 08-р сарын 15-нд хүртэл зусланд байх, Ховд голын сав газарт 08-р сарын 30-нд намаржаанд буух, 09-р сарын 25 оторт гарч, 11-р сарын 01 нд өвөлжөөнд бууна. /

Тухайн үеийн нүүдлийн хугацааг цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан өөрчлөлт оруулах

3.2.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төслийг Газрын тухай хуульд заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

3.3.Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, ИТХ-д тайлагнана.

3.4 Бог малын хээлтүүлэгчийн суурийг БИНХ-ын саналыг үндэслэн сумын Засаг дарга зусах, намаржих нутгийг батлана.

3.5.Нөөцөлсөн нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед сумын Засаг дарга шийдвэр гарган хэрэгжилтийг зохион байгуулна.

3.6.Малчдын бүлэг, айл өрх саахалтаараа хэлэлцэн тодорхой бэлчээр нутгийг нөөцлөн бэлчээрийн менежментийг сайжруулан ашиглахыг дэмжиж уг бэлчээр нутгийг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг ИНХ-аар хэлэлцүүлж болно.

3.7.Сумын нутагт ашиглагддаггүй алсын бэлчээрийг ашиглах зорилгоор уст цэг гарган тэлж ашиглаж байгаа малчдын бүлэг, иргэдийг бодлогоор дэмжин тухайн жилийн бэлчээрийн хуваарьт тусгаж ажиллана.

3.8.Сумын бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжиж, хаваржих малыг оруулахдаа энэ журам болон БИНХ-ын шийдвэрийг танилцуулж, зөвшилцсөний үндсэн дээр тухайн малчин өрхтэй гэрээ байгуулж, бэлчээр нутгийг зааж өгч нэвтрүүлнэ.

Дөрөв. Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг иргэдийн санал болон, ашиглагдахгүй байгаа газар нутгийн судалгааг гарган багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах

4.2.Ашиглахгүй байгаа газар нутагт хаваржиж, зусаж, намаржиж байгаа айл өрхүүдэд төрийн үйлчилгээ хүргэх ажлыг зохион байгуулах

4.3.Бэлчээр ашиглалтын хуваарийг зөрчсөн малчин, мал бүхий иргэнд хугацаатай мэдэгдэх хуудас өгч, сумын Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

4.4.Бэлчээрийн хуваарийн дагуу газраа чөлөөлөөгүй малчин, мал бүхий иргэнийг албадан нүүлгэж, гарсан зардлыг тухайн малчнаас гаргуулах,

**Тав. Сумын хөдөө аж ахуйн тасаг дараах үйл ажиллагааг
хэрэгжүүлнэ:**

5.1.Бэлчээр ашиглалтын хуваарийн төсөлд тусгах саналыг багийн Засаг дарга болон БИНХ-аас авч тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах ажлыг зохион байгуулах.

5.2.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт-шинжилгээ үнэлгээг хийлгэх, бэлчээрийг ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг боловсруулах

5.3.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах,

5.4.Нөөцөлсөн нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед санал боловсруулан сумын Засаг дарга танилцуулах,

5.5.Жил бүр бэлчээр, хадлангийн газарт фото мониторинг хийж дүнг олон жилийн дундажтай харьцуулан заасан бэлчээр ашиглагчдын хэсэг, малчин өрх, орон нутгийн удирдлагад мэдээлэх,

5.6.Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь хэсэгт заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

5.7.Өвөлжөө, хаваржаа, худаг уст цэгийн байршлыг тогтоож мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэх;

5.8.Бог малын хээлтүүлэгчийг маллаж буй малчид, мал бүхий иргэд жил бүрийн 12 дугаар сарын 31-нээс өмнө хээлтүүлэгч малыг суурь зохион байгуулалтад оруулсан байх.

**Зургаа. Сумын газрын даамал дараах үйл ажиллагааг
хэрэгжүүлнэ**

6.1.Сумын нөөц бэлчээрийн хэмжээ, байршлыг газрын нэгдмэл сангийн бусад ангиллын газартай давхцуулахгүйгээр зураглан мэдээллийн санд оруулах,

Долоо. Малчид, мал бүхий иргэдийн хүлээх үүрэг:

7.1.Сумын малчид, мал бүхий иргэд тогтоолд заасан зуслангийн газруудад бэлчээрийг ашиглаж, зусаж байгаа газрынхаа гол ус, байгаль орчныг бохирдуулахгүй байх,

7.2.Сумын ИТХ-аас батлагдсан хуваарийн дагуу нутаг дэвсгэрт хамаарагдах зуслангийн газрыг сумын малчид, мал бүхий иргэд нийтээрээ эзэмших,

7.3.Бусад сум, орон нутгаас малчдын малыг авч маллахгүй байх, бусад зэргэлдээ аймаг сумын малчдын малыг зусуулахгүй байх, мал худалдаж авах, бэлгэнд авах тохиолдолд сумын мал эмнэлгийн үржлийн нэгжид мэдэгдэж урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах

7.4.Сумын Засаг дарга болон холбогдох байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх,

7.5.Тухайн жилийн бэлчээрийн хуваарь, бэлчээрийг зүй зохистой ашиглах талаарх саналаа БИНХ-аар дамжуулан өгөх

7.6.Өөрийн ашиглаж байгаа бэлчээрт ой хээрийн түймэр болон байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагад мэдээллэх

7.7.Гол, горхи, булаг шандны эх ундаргыг хамгаалахаас бусад тохиолдолд бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх

7.8.Бэлчээрийн хуваарийн дагуу газраа чөлөөлөөгүй тохиолдолд албадан нүүлгэсэн зардлыг тухайн малчин хариуцан төлнө.

Найм.Сумын мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.1.Сумын нийт мал сүргийг элдэв паразит шимэгч хорхой, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг мал эмнэлгийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах .

8.2.Малын шилжилт хөдөлгөөн мал амьтны гаралтай хүнсний болон түүхий эд бүтээгдэхүүний ариун цэвэр аюулгүй байдалд баталгаажуулалтын хяналт тогтмол хийх.

8.3.Өөр аймаг сумдаас орж ирэх болон отрын малын гарал үүсэл, мал эмнэлгийн тасгийн тодорхойлолтыг үндэслэх ,шаардлагатай тохиолдолд ариутгал халдваргүйжүүлэлт хийж сумын хилээр нэвтрүүлэх.

Ес.Журмын биелэлтийг хангах талаар:

9.1.Энэ журмыг хэрэгжүүлэх, зохион байгуулж, хяналт тавих ажиллах ажлын хэсгийн багийн Засаг дарга нар, Багийн ИНХ-ын дарга, тэргүүлэгчид, Байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Татварын улсын байцаагч, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, сумын хэсгийн төлөөлөгч, Малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний төлөөллийг оролцуулан сумын Засаг даргын шийдвэрээр ажлын хэсэг байгуулан тогтмол ажиллуулах.

Арав. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох, хохирол нөхөн төлүүлэх:

10.1.Энэхүү журмын зөрчсөн малчид, иргэн, аж ахуй нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг үндэслэн сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны улсын байцаагч дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

10.2.Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 8.1.6, 8.1.8-д заасны дагуу хариуцлага тооцно.

10.3.Бэлчээр ашиглалтын хуваарь зөрчиж нүүгээгүйн улмаас малаараа бусдын бэлчээр идүүлсэн малчин, мал бүхий иргэнийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 заалтуудыг тус тус үндэслэл болгон Газрын харилцаа геодези зураг зүйн газраас гаргасан аргачлалын дагуу бэлчээрт учирсан хохирлыг тооцож нөхөн төлбөр оногдуулж, төлбөрийг орон нутгийн хүү торгуулийн орлогын дансанд төвлөрүүлнэ

10.4.Бэлчээрийн бүс нутгийн улирлын хуваарь зөрчин, бусдын өвөлжөө хаваржаанд хохирол учруулбал албадан 3.5 -д заасны дагуу нүүлгэн , гарах зардлыг тухайн малчнаас гаргуулна.

Арван нэг. Маргаан шийдвэрлэх

11.1.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

11.2.Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 7342 дугаарт бүртгэв.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 8 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/1176

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛ, АЧААЛЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025-2026 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай:

1.1.Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/1037 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”-ын 2.2-т заасны дагуу автомашины улсын дугаарын сүүлчийн орон нь тэгш тоо (0, 2, 4, 6, 8) -гоор төгссөн автомашиныг 2025 оны 08 дугаар сарын 28, 30, 09 дүгээр сарын 02, 04, 06, 08, 10, 12, 14, 16-ны өдрүүдэд, сүүлчийн орон нь сондгой тоо (1, 3, 5, 7, 9)-оор төгссөн автомашиныг 2025 оны 08 дугаар сарын 27, 29, 31, 09 дүгээр сарын 03, 05, 07, 09, 11, 13, 15-ны өдрүүдэд, 08:00-20:00 цагийн хооронд бүсчлэлгүйгээр тус тус замын хөдөлгөөнд оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар (С.Галбадрах), “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа)-д;

1.2.Энэ захирамжийн 1.1-д заасан арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/1037 дугаар захирамжийн

1 дүгээр хавсралтаар баталсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”-ын 2.3-т зааснаас гадна зохих зөвшөөрөл, тоноглол бүхий бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүний түгээлт, татан авалт, оршуулга, авто зам, хот тохижилт, шугам сүлжээний засвар, үйлчилгээ, дипломат байгууллага болон гадаад улсын зочин, төлөөлөгчид үйлчлэх, нийтийн тээвэр, стандартын шаардлага хангасан такси үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, байгууллагын ажилчдыг тээвэрлэх үйл ажиллагаанд ашиглах болон таних тэмдэг бүхий хэвлэл мэдээллийн байгууллагын тээврийн хэрэгслийг хамааруулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Нийслэлийн цагдаагийн удирдах газар (Э.Товуудорж), Тээврийн цагдаагийн алба Замын цагдаагийн газар (С.Галбадрах), “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа)-т;

1.3.Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ, чиглэлийг шинэчлэн тогтоож, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Нийтийн тээврийн бодлогын газар (Д.Отгонжаргал)-т;

1.4.Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Баярцэцэг)-т.

2.Энэ захирамжгарсантай холбогдуулан Цагдаагийн байгууллагаас ажиллах албан хаагчдын хоол, шатахууны нэмэлт зардлыг төсвийн холбогдох зардлаас гаргахыг Нийслэлийн Засаг даргын тамгын газар (Д.Амгалан)-т зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Т.Даваадалай)-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

Handwritten: ~~Handwritten~~ ~~Handwritten~~

[illegible][illegible][illegible][illegible][illegible]

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 7343 дугаарт бүртгэв.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 04/15

Цомог

МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалтууд, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, 59 дүгээр зүйл, 62 дугаар зүйл, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын малчид, мал бүхий иргэдийн нэг малын тоо толгойд ногдуулах жилийн албан татварын хувь хэмжээг тэмээ-0, адуу-300 (гурван зуу), үхэр-300 (гурван зуу), хонь-100 (нэг зуу), ямаа-100 (нэг зуу) төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 05/10 дугаар тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 20/06 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Батлагдсан тогтоолыг Хууль зүйн яаманд бүртгүүлэн тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч (И.Уугантуяа)-д даалгасугай.

4.Тус тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлэгдсний дараа дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Э.СҮХБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 08

Хөхөө

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит бус VIII хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1.Сумын “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын хэрэгжилтийг ханган, үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж, ажиллахыг сумын Засаг дарга (Д.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдөх, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн тасаг, сумын Засаг дарга (Д.Болд-Эрдэнэ)-д даалгасугай.

4.Тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баярцэцэг)-т даалгасугай

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн II/04 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Х.ЭНХТҮВШИН

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит
бус хоёрдугаар хуралдааны 08 дугаар
тогтоолын хавсралт*

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Бэлчээрийг орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхид суурилсан аргачлалаар улирлын хуваарьтай төлөвлөх, бэлчээрийн даац, багтаамжид тохируулан малын тоо толгойн зохистой хэмжээг бий болгож, тус сумын нийт нутаг дэвсгэрийн 70 хувь нь ой болон усан бүхий газар бөгөөд бэлчээр байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалахад нутгийн захиргаа, орон нутгийн болон отрын малчдын хооронд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулахад оршино.

1.2.Сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахад бэлчээр, ус ашиглагч малчид, бүлэг, аж ахуйн нэгж, байгууллагууд энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална

2.1.1.Бэлчээрийн даац, багтаамж, экологийн чадавхид суурилах

2.1.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах

2.2.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө /цаашид “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гэх/ нь дараах шаардлагыг хангасан байна.

2.2.1.Бэлчээрийн төлөв байдал чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний /фотомониторинг гэх/ дүнд үндэслэсэн байх

2.2.2.Бэлчээрийг улирлаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарь гаргах

2.2.3.Бэлчээрийг улирлаар ашиглах, өвөлжөөний бэлчээрийг жил бүрийн 3-сарын 25, хаваржааны бэлчээрийг 5 сарын 25, зуслангийн бэлчээр 9 сарын 25, намаржааны бэлчээрийг 11 сарын 1-нд чөлөөлсөн байна. Тухайн жилийн цаг агаар болон бусад цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан бэлчээр чөлөөлөх цаг хугацаанд багийн Засаг даргын хүсэлтээр сумын Бэлчээр ашиглалт отор нүүдэл зохицуулах зөвлөл өөрчлөлт оруулж болно.

Гурав. Бэлчээрийн даац тооцох

3.1.Үндэсний статистикийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/113, А/250, А/422 дугаар хамтарсан тушаалын хавсралт «Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал»-ын дагуу тооцно.

Дөрөв. Бэлчээр ашиглалтын талаар сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны болон тухайн шатны Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

4.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1.Багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн Газрын тухай хуулийн 20.1.2, 52.6-д заасны дагуу сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн тусгайлан (өвөлжөө, хаваржаа, хадлангийн талбай, отрын, өнжөөх, чөлөөлөх) болон нийтээр (зуслан, намаржаа, худаг, нуур, булаг, хужир) ашиглах бэлчээрийн заагийг газрын зурагт тэмдэглэн 5, 9 сард тогтоож сумын Засаг дарга өргөн мэдүүлснийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.1.2.Сумын бэлчээрийн даацад нийцсэн сүргийн зохистой бүтэц, малын тооны оновчтой хэмжээг тогтоож батлах, авах арга хэмжээний чиглэлийг баталж, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

4.1.3.Сумын Засаг даргын дэргэд “Отор нүүдэл зохицуулах зөвлөл” ажиллууна. Тус зөвлөлд Засаг дарын орлогч, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, байгаль орчны улсын байцаагч, татварын байцаагч, мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, багийн Засаг дарга нар байна.

4.2 .Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.1.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг багийн Засаг даргатай хамтран зохион байгуулах, шалгах, тайлагнах

4.2.2.Багийн Засаг даргын жилийн ажлыг үнэлэхдээ энэ журмын хэрэгжилтийн үр дүнг тооцох

4.2.3.Гол, горхи, булаг, шандын эх ундарга, хадлангийн болон тариалангийн талбай хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах сургалтыг зохион байгуулах

4.2.4.Гантай эсвэл өвөлжилт хүндэрсэн өөрийн сумын багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй багийн нутаг дэвсгэрт айл өрх мал сүргийг тухайн багийн Засаг даргатай зөвшилцөн оруулах шийдвэр гаргах

4.2.5.Малчид, малчдын бүлэгт нэг наст болон олон наст ургамал тариалах, эрчимжсэн мал аж ахуй төрөлжүүлэн хөгжүүлэх зэрэгт бодлогоор дэмжих, арга зүйгээр хангах

4.2.6.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг үр дүнтэй хэрэгжүүлсэн, алслагдсан болон ашиглалтгүй бэлчээрийг ашигласан, өвөл, зуны отор нүүдэл хийсэн, хадлангийн талбайг тордож сайжруулсан, бууцны хөлд ногоон тэжээл тариалах зэргээр манлайлан ажилласан малчид, малчдын бүлэг, хэсэгт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох.

4.2.7.Өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжиж, хаваржих малыг оруулахдаа харьяа сумын Засаг даргын албан хүсэлт, отрын малчдад нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх гэрээ отроор ирж байгаа малчинаас хэдэн ам бүлтэй, хэдэн тооны малтай малчин өрх хэдий хугацаагаар орж ирж байгаа талаар дэлгэрэнгүй өргөдлийг авч болзолт гэрээ байгуулан бэлчээрийн хураамжийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэний дараа нутаглах өвөл, хаврын бэлчээр нутаг зааж өгөх

4.2.8.Бэлчээрийн даацад нөлөөлөхүйц /100 толгойгоос дээш адуу,100 дээш толгой үхэр, 200 толгойгоос дээш ямаа, 100 толгойгоос дээш хонь/ малтай оторчин өрхтэй зөвшилцөж тус нутагт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

4.2.9.Гамшиг, аюулт үзэгдлийн улмаас бусад аймаг, сумын малыг отрын бэлчээр болон бусад бэлчээрт түр хугацаагаар оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх;

4.3.Багийн Иргэдийн Нийтийн Хурлаас дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.1.Энэ журмын 2.2-д заасны дагуу төлөвлөгөөний төслийг сумын хөдөө аж ахуйн тасагтай хамтран боловсруулж хурлаараа хэлэлцэн жил бүрийн 5, 9 сарын 5-нд багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх

4.3.2.“Бэлчээр ашиглалтыг хариуцлагжуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа сумын Засаг даргад уламжлах, бэлчээрийн маргаантай асуудлыг шалгаж, шийдвэрлэх

4.3.3.Уг журмын хэрэгжилтийн талаарх багийн Засаг даргын жилийн тайланг хэлэлцэж, дүгнэж, шийдвэр гаргах

4.4.Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.4.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, санал авах, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

4.4.2.Тухайн жилд хэрэгжүүлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсөлд малчин өрх, малчдын бүлэг, бэлчээр ашиглалтын хэсгийн саналыг авч тусгах, сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах.

4.4.3.Багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан санал, шийдвэр, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, бэлчээр ашиглах хуваарийг малчин өрхүүдэд танилцуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.

4.4.4.Бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн талбай болон бэлчээр, уст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулах.

4.4.5.Гадны нутаг (отор)-оос (гэрээ, зөвшөөрөл, мал эмнэлгийн гэрчилгээ)-гүй орж ирсэн малчидтай нэн даруй уулзаж, шаардлага өгч, нүүлгэх, нутаг бэлчээр олгохгүй байх саналыг Мэл эмнэлгийн тасагт бичгээр уламжлах

4.4.6.Малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, харьцаа, үүлдэр угсаа, шилэн сонголт, чанар сайжруулахад анхаарч ажиллах, мал эмнэлгийн тусламж үйлчилгээнд малчдыг бүрэн хамруулах

4.4.7.“Бэлчээр ашиглалтыг хариуцлагжуулах журам” зөрчсөн этгээдэд хугацаатай мэдэгдэх хуудас өгч, сумын Засаг даргад нэн даруй бичгээр мэдэгдэх

4.4.8.Бэлчээрийг хуваарийн дагуу чөлөөлөөгүй этгээдийг албадан нүүлгэж, гарсан зардлыг төлүүлэх

4.4.9.Өвөлжөө хаваржааны ашиглалтын судалгааг жил бүр гаргаж газрын даамалд хүргүүлж Сумын Засаг даргад уламжилна.

4.4.10.Малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-аас тогтоосны дагуу төвлөрүүлэх ажлыг хийж хэрэгжүүлнэ.

4.5.Сумын Мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.5.1.Сумын нийт мал сүргийг шимэгчтэх, халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг мал эмнэлгийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах

4.5.2.Гадны нутгаас болон отрын малд гарал үүсэл, эрүүл ахуй, мал эмнэлэгийн гэрчилгээ, өрхийн эрүүл мэндийн дэвтрийг үндэслэн, ариутгал халдваргүйжүүлэлт хийж сумын хилээр нэвтрүүлэх

4.6.Сумын Хөдөө аж ахуйн тасаг, Газрын даамал, Сумын байгаль орчны асуудал харицсан мэргэжилтэн, Байгаль орчны хяналтын улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

4.6.1.Малчдад бэлчээр ашиглалтын ач холбогдлыг ойлгуулж, мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх сайжруулах талаар сургалт зохион байгуулах бэлчээрийг зөв зохистой ашиглах дадалтай болгох

4.6.2.Багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан саналыг тухайн багийн бэлчээр ашиглалтын хуваарийн төсөлд тусгуулах арга хэмжээ авах

4.6.3.Сум, багийн түвшинд бэлчээрийн даацыг тогтоон, өвөлжиж, хаваржих боломжит малын тоог тодорхойлсон дүнгийн хамт жил бүрийн 09 дүгээр сарын 20-наас 30-ны дотор аймаг, сум, багийн Засаг даргад хүргүүлэх;

4.6.4.Бэлчээрийн даац, багтаамжийн дүнд тулгуурлан тухайн жилд малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, хэмжээ, сүргийн эргэлтийг оновчтой зохион байгуулж, мал аж ахуйг үр ашигтай эрхлэн явуулахад тоонд бус чанарт анхаарч өндөр ашиг шимтэй сумын цөм сүргийг бий болгох сургалт, сурталчилгаа хийнэ.

4.6.5.Цаг агаарын урьдчилсан мэдээллээр хангах, масс мэдээ илгээх

4.6.6.Газар эзэмших эрхийн гэрчилгээг /өвөлжөө хаваржаа/ бусдад шилжүүлэхэд багийн Засаг даргаас тодорхойлолт авч Газрын даамалд уламжилна.

4.6.7.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төслийг боловсруулахад оролцож багийн иргэдийн Нийтийн Хуралд саналаа хүргүүлэх.

4.6.8.Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг үндэслэн бэлчээрийн хураамжийг тооцож орон нутгийн орлогын дансанд шилжүүлнэ.

Тав.Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг

5.1.Бэлчээр ашиглагч малчин, бүлэг дараах нийтлэг эрх, үүрэгтэй

5.1.1.Бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулахад биечлэн оролцох

5.1.2.Бэлчээр өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гаргасан сум, багийн Засаг даргын шийдвэрийг дагаж биелүүлэх

5.1.3.Малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-ын тогтоосон хэмжээгээр хуулийн хугацаанд төлөх

5.1.4.Гаднаас дур мэдэн отрын айл, мал сүргийг зөвшөөрөлгүй оруулж, өвөлжөө, хаваржаа, хот бууцыг дамжуулан ашиглуулахгүй, бэлчээр хашихгүй байх

5.1.5.Сум, багийн Засаг даргын зөвшөөрөлгүй шинээр хашаа, хороо барих, уст цэг гаргах, ашиглах, эзэмших бусдад өвөлжөө, хаваржааны газар олгох, худалдах, шилжүүлэх, бэлэглэхийг хориглоно.

5.1.6.Өвөлжөө, хаваржаандаа гадны мал бүхий өрх буулгахыг хориглоно.

5.1.7.Бэлчээр, хашаа, саравч, бууц, усны эх үүсвэрийг бохирдуулахгүй, малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж, хортон мэрэгчтэй тэмцэх, сумын мал эмнэлгээр ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, устгах

5.1.8.Энэ журмын 2.2.3-д заасан зайд мал бэлчээхгүй, оторлохгүй, хашаа саравч дур мэдэн барихгүй байх. Байгалийн хадлан бэлтгэдэг талбайд хариуллагагүй мал оруулах, хадлан өвс бэлтгэх үед саад учруулах, өвөл хаврын бэлчээр идүүлэхгүй байх.

5.1.9.Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд өвөлжөө, хаваржаа барих асуудлыг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар гаргасан саналыг үндэслэн сумын Засаг дарга зохицуулж шийдвэрлэнэ

5.1.10.Шилжин ирэхээр хүсэлтээ гаргасан малчин өрхийг “Монгол Улсын нутаг дэвсгэрт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын 2.1-т заасны дагуу өрхийн хүсэлтийгхүлээн авч тухайн багийн нутаг дэвсгэрийн бэлчээрийн даацыг харгалзан багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар өвөлжөө хаваржааны газар эзэмшүүлэх эрх үүсгэнэ.

5.1.11.Отрын бэлчээрт өвөлжиж, хаваржсан малчид ашиглаж байсан бэлчээр дэх малын сэг зэм, ахуйн хог хаягдлыг цэвэрлэж бэлчээрийг чөлөөлнө.

Зургаа.Маргаан шийдвэрлэх хохирол нөхөн төлүүлэх

6.1.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан маргааныг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

6.2.Журам зөрчсөн маргааныг сумын Засаг дарга шийдвэрлэнэ. Эс тохиролцсон тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Журам хүчин төгөлдөр болох

7.1.Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр болно.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 7345 дугаарт бүртгэв.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 6 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 34

Сант сум

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны “Аргачлал батлах тухай” 192, А/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх зардлын нэгж тарифыг 4950 төгрөг байхаар баталсугай.

2.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Л.СЭЛЭНГЭСАЙХАН

የግንባታ ስራ ላይ የሚሳተፉት ሰራተኛዎች በሰላማዊነት እና በሰላም ስራ ላይ ይሳተፋሉ፡፡

ԳՆՀԽՆՈՒՆԵՆ, ԶԻՆԴԱՆՈՒ ՆԵՐՈՒՆ ԵՎ ԴՆԻՆ/ՈՒՐԴՈՒ Ե ՎԵՐԱՄԵ ՆԵՐԱԶԱՆՈՒՄԷ - ԵՆ ՎԵՆ ՎԵՆ ՆԵՐԱԶԱՆՈՒՄ/ՎԵՐԱԶԱՆՈՒՄ
 ԵՐԱՆԻ ՎԵՐԱՆԻՆ ԵՎ ՈՒ ԵՐԱՆԻ ՄԻՈՒՅԱԶԱՆՈՒՄ/ՅԻ ՄԻՈՒՅԱԶԱՆՈՒՄ/ՈՒ «ԿՆՆ ԵՎ ՄԵՆ ՄԻՆԱԶԱՆՈՒ Ե ՄԻՈՒՆԵՆ, ՄԱՆՈՒՅԱԶԱՆՈՒ,
 ԿԵՐՈՒՆ ՆԵՐԱԶԱՆՈՒՄ ԵՎ ԿԵՐԱՆ ԵՎ ՄԻՆԱԶԱՆՈՒՄ/ՈՒՅԼ ՆԵՎ Յ «ՆԵՐԱԶԱՆՈՒ ՄԻՈՒՆԵՆ ՎՈՒՄ» ԳՆՈ, Խ/ՈՒՅԼ
 ՄԻՆԱԶԱՆՈՒ ԵՎ ՎՈՒՄ ՄԻՈՒՆ ՈՒ/Ն ԵՐԱՆԻ ՆԱՐԱՆ ԵՎ Ն.Ո.Յ ԵՐԱՆ ՆԱԶԱՆՈՒ, ԿՆՆ ԵՎ ԿԵՐԱՆ, ՅԻՆԱԶԱՆՈՒ ՆԵՐԱՆ/ՈՒ,
 ՆԱՐԱՆ ԵՎ ՅԼ Յ ԵՐԱՆ ՈՒՐԴ, ՆԵՐԱԶԱՆ/Յ ՆԵՐԱՆՈՒ ՄԻՈՒՆ ՈՒ ԵՐԱՆ ՆԱՐԱՆ ԵՎ ԵՐԱՆ Յ ԵՐԱՆ ՈՒՐԴ, ՄԵՆ
 ՈՒ/ՈՒՅ ԵՐԱՆ ՆԱՐԱՆ ԵՎ ՈՒՅ ԿՆՆ ՆԱՐԱՆ ԵՎ ԵՐԱՆ Յ ԿՆՆ ՆԱՐԱՆ ԵՎ ԵՐԱՆ Յ ԿՆՆ ՆԱՐԱՆ, ՅԼ ԵՐԱՆ
 ՆԵՐԱՆ ՆԱՐԱՆ ԵՎ ՆԵՐԱՆ ՆԵՐԱՆ/ՈՒՐԴ ՎԵՐԱՆՈՒՄ/ՈՒ ԴՆԻՆ/ՈՒ, ՎԵՐԱՆ Յ ՆԵՐԱԶԱՆՈՒՄ/ՈՒ ՆԱՐԱՆ ՆԱՐԱՆ

॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥
 ॥ ॐ नमो भगवते वासुदेवाय ॥

॥ श्रीगणेशाय नमः ॥

12

2000



ଆଜିର ଓ ଭବିଷ୍ୟତର ଓ ନିଜର ଓ ଅନ୍ୟାନ୍ୟ
 ଶାନ୍ତିର ଆରମ୍ଭ ଓ ଆଗାମୀ ଶାନ୍ତିର

१५५५

for a long time

Бүтээгдэхүүн № **A** 2010 оны дүн

Служба доставки
г. Москва
Курьерская служба
Телефон 233-33-33
Мототранспортная служба
187-7070

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 7346 дугаарт бүртгэв.

ДОРНОД АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 16

Чойбалсан

ҮНЭ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 заалтуудыг тус тус үндэслэн Альфа илч ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Зохицуулах зөвлөлийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Баян-Уул сумын Альфа илч ХХК-ийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний үнэ тарифыг хавсралтаар баталсугай.

2.Дулааны эрчим хүчний үнэ тарифыг Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Альфа илч ХХК-ийн гүйцэтгэх захирал / Д.Бямбадорж /-д даалгасугай.

3.Үнэ тарифын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүн Ж.Энхээд даалгасугай.

ДАРГА

Д.БАТБИЛЭГ

ГИШҮҮН

Ж.ЭНХЭЭ

ГИШҮҮН

Б.УРАНСҮХ

*Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 16 дугаар тогтоолын
хавсралт*

**БАЯН-УУЛ СУМЫН “АЛЬФА ИЛЧ” ХХК-ИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ТАРИФ**

Дорнод аймгийн Баян-Уул сумын “Альфа илч” ХХК-ийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон тус сумын хэрэглэгчдэд / төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүд, айл өрхийн хэрэглэгч / борлуулах дулааны эрчим хүчний тариф /НӨАТ-гүй/-ыг төлбөр тооцох үзүүлэлтийн ангилалд дараах байдлаар тогтооно.

Д/Д	ХЭРЭГЛЭГЧИЙН АНГИЛАЛ	ХЭМЖИХ НЭГЖ	ТАРИФ /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагуудын халаалт	Төг/м3	2300.00
2	Аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м3	2300.00
3	Айл өрхийн халаалт	Төг/м2	1000.00

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 8 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/337

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 232 дугаар зүйлийн 232.2 дахь хэсэг, 271¹ дэх зүйлийн 271^{1.1.2} дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 05/06, 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 07/03 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Гаалийн бүрдүүлэлтийг доор дурдсан хугацаанд хийж байхаар тогтоосугай:

2.1.хилийн боомтод ажиллаж байгаа гаалийн байгууллага Засгийн газар хоорондын хэлэлцээрт заасан хугацаанд;

2.2.олон улсын нисэх буудалд ажиллаж байгаа гаалийн байгууллага тухайн хилийн боомтын ажиллах цагийн хуваарийн дагуу;

2.3.гүний гаалийн байгууллага ажлын өдрүүдэд ажлын цагт;

2.4.төмөр замын дагуу байрлах гүний гаалийн байгууллага энэ тушаалын 2.3-т заасан хугацаанаас гадна шаардлагатай тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдрүүдэд.

3.Энэ журмыг гаалийн харилцаанд оролцогчдод сурталчлан таниулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар (Б.Даваасүрэн), Хуулийн хэлтэс (Ч.Тамираа)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тус журамд нийцүүлэн гаалийн байгууллагын автоматжуулсан удирдлагын системд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулахыг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн газар (Б.Ганзориг)-т даалгасугай.

5. Тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны “Журам батлах тухай” А/275 дугаар тушаал, 2022 оны “Түр заавар батлах тухай” А/19 дүгээр тушаал, мөн оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/347 дугаар тушаал, 2025 оны “Журамд нэмэлт оруулах тухай” А/17 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

*Гаалийн ерөнхий газрын даргын
2025 оны 8 дугаар сарын 25-ны
өдрийн А/337 дугаар тушаалын хавсралт*

**ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ БАРАА, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД
ГААЛИЙН ХЯНАЛТ ТАВИХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийх дэс дараалал, үйл ажиллагааны зааврыг тогтооход энэ журмын зорилго оршино.

1.2. Гаалийн хяналт тавих, бүрдүүлэлт хийх албан тушаалтан гаалийн мэдээллийн автоматжуулсан систем (цаашид “CAIS” систем гэх), хорио цээрийн удирдлагын мэдээллийн систем (“QIMS”)-д зөвхөн өөрт олгогдсон эрхээр нэвтэрч, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Гаалийн харилцаанд оролцогч нь гадаад худалдааны үйлчилгээ эрхлэгчдийн систем (цаашид “CEPS” систем, “GAALI.mn”)-д өөрийн эрхээр нэвтэрч гаалийн харилцаанд оролцоно. Эрхээ бусдад ашиглуулснаас гарах үр дагаврыг эрх эзэмшигч бүрэн хариуцна.

1.3. Гаалийн байгууллага, албан тушаалтан гаалийн хяналтын бүх үе шатанд ажиглалт хийнэ.

1.4. Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд теле хяналтын нэгдсэн систем, хяналт, шалгалтын техник, багаж хэрэгсэл, энгэрийн камер, эрэлч нохой, мэдээллийн санг ашиглана.

1.5. Гаалийн тухай хуулийн 240 дүгээр зүйлд заасан гаалийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гаалийн хяналт, шалгалтын явц, үр дүн, илэрсэн зөрчлийг бэхжүүлэн авах зорилгоор дуу авиа, дүрс бичлэгээр баталгаажуулна. Гаалийн зорилгоор дуу авиа, дүрс бичлэгийг хийх, хадгалах зэрэгтэй холбогдсон үйл ажиллагаанд “Гаалийн хяналт, шалгалтын явцад дуу авиа, дүрс бичлэг хийх, ашиглах заавар”-ыг дагаж мөрдөнө.

1.6. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтад үндэслэн тээвэрлэгч, тээвэр зуучлалын байгууллага CEPS системд “Ачааны манифест”-ыг нөхөн бичиж, гаалийн байгууллагад цахимаар илгээнэ. ТИР карней бүхий тээврийн хэрэгслийг Олон Улсын гэрээ, конвенцийн дагуу шийдвэрлэнэ.

1.7. Ачааны манифестыг тээвэрлэгч болон тээвэр зуучлалын байгууллага цахимаар нөхөн бичих, гаалийн байгууллага хянахад “Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам”-ыг дагаж мөрдөнө.

1.8.Ачааны манифестын мэдээллийг Монгол Улсын гаалийн байгууллага, бусад орны гаалийн байгууллагатай байгуулсан хэлэлцээрийн дагуу цахимаар солилцож болно.

1.9.Гаалийн бүрдүүлэлтийн явцад гаалийн хууль тогтоомжийн зөрчилтэй холбоотой үндэслэлтэй мэдээлэл хүлээн авсан тохиолдолд нэн даруй гаалийн хяналт, бүрдүүлэлт, хорио цээр, эрсдэл, зөрчилтэй тэмцэх асуудал хариуцсан нэгжийн холбогдох албан тушаалтан CAIS системийн гаалийн мэдүүлгийн “Мэдээлэл” талбарт зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг тодорхой бичиж оруулна.

1.10.Бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, бүрдүүлэлт хийж буй албан тушаалтанд зөвлөмж, чиглэлийг албан бичгээр, эсхүл CAIS системийн холбогдох мэдээллийн талбараар дамжуулан мэдэгдэж, зөвлөмж, мэдээллийг хүргүүлсэн албан тушаалтан биелэлтэд хяналт тавина.

1.11.Гаалийн хилээр нэвтрүүлэх хориглосон, хязгаарласан бараатай холбоотой мэдээллийг эрх бүхий удирдах албан тушаалтан харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан зөвлөмж, чиглэлийг хүргүүлж болно. Хүргүүлсэн мэдээлэл, зөвлөмжийг 24 цагийн дотор албан бичгээр цахимаар хүргүүлж, эсхүл CAIS системийн холбогдох мэдээллийн талбарт оруулж баталгаажуулна.

1.12.Ухаалаг гарц суурилуулсан хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд бараа, тээврийн хэрэгслийг бүртгэх, хяналт тавихад холбогдох зааврыг дагаж мөрдөнө.

1.13.Бараа, тээврийн хэрэгслийн шалгалтыг гаалийн хяналтын бүс, баталгаат бүс, чөлөөт бүсэд хийнэ. Түргэн муудах, аюултай, хагарч гэмтэх, ачилт, хадгалалт, тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардагдах, төрийн болон албаны нууцад хамаарах, түүнчлэн түүх соёлын дурсгалт зүйлс, валют, валютын үнэт зүйлс, химийн бодис, Монгол Улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн газар, түүнтэй адилтгах бусад байгууллагын бараа, мөн зайлшгүй шаардлагатай бусад барааны шалгалтыг мэдүүлэгчээс цахимаар эсхүл бичгээр гаргасан хүсэлтийн дагуу өөр газарт, ажлын өдөрт ажлын цагт багтаан мэдүүлэгчийн зардлаар хийж болно.

1.14.Мал, амьтныг хилийн гаалийн хяналтын бүсэд оруулмагц мал эмнэлгийн хяналт хариуцсан албан тушаалтан эрүүл мэндийн анхдагч үзлэгийг 1 цагийн дотор хийж эхлэх бөгөөд бичиг баримтыг шалган тэмдэглэл үйлдэж, энгэрийн камерын бичлэгээр баталгаажуулна.

1.15.Улсын хилээр оруулах ургамал, ургамлын гаралтай түүхий эд, тарих үрийн материал /амьд үр, суулгац, тарьц, хөврөл, ургал эрхтэн/, хүнсний болон үйлдвэрлэлийн зориулалттай үр тариа, улаан буудайн гурил, төрөл бүрийн будааг хилийн гаалийн хяналтын бүсэд оруулмагц

ургамлын хорио цээрийн хяналт хариуцсан албан тушаалтан тээврийн хэрэгслээс буулгахгүйгээр хортон шавж, хог ургамал, ургамлын өвчин илрүүлэх анхдагч үзлэгийг 1 цагийн дотор хийж эхлэх бөгөөд бичиг баримтыг шалган тэмдэглэл үйлдэж, энгэрийн камерын бичлэгээр баталгаажуулна.

1.16.Эрүүл мэндийн болон анхдагч үзлэгээр өвчний шинж тэмдэг, хөнөөлт организмын сэжигтэй тохиолдол илэрсэн үед мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр тусгаарлан, саатуулж, хорио цээрийн хяналтад оруулан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулна. Энэхүү хорио цээрийн хяналтыг тусгайлан бэлтгэсэн түр тусгаарлах хэсэгт хийнэ.

1.17.Саатуулсан хугацаанд амьтны гоц халдварт өвчин, ургамлын гадаад хорио цээртэй зүйл илэрсэн нь баталгаажсан тохиолдолд тухайн үзлэг хийсэн албан тушаалтан экспортлогч улсад буцаах мэдэгдлийг нэн даруй өгч, эсхүл гаалийн байгууллагын хяналт дор устгах арга хэмжээ авах шийдвэр гаргаж, тухайн гаалийн байгууллагын удирдлагад мэдэгдэнэ.

1.18.Улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэсэн байна.

1.19.Улсын хилээр нэвтрүүлэх мал амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, хуучин хувцас, шарил тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл халдваргүйжүүлэлтийн гэрчилгээтэй байна.

1.20.Дор дурдсан барааг мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэсний үндсэн дээр улсын хилээр нэвтрүүлнэ.

1.20.1.олон улсын хөл хориот өвчний сэжиг илэрсэн болон онош батлагдсан зорчигчийн гар тээш, дагалдах ачаа, эд зүйлс;

1.20.2.хүний шарил;

1.20.3.дотоод хорио цээртэй зүйлс илэрсэн ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн;

1.20.4.халдварын сэжигтэй мал, амьтан, ургамлын хорио цээртэй зүйлс илэрсэн ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл, хашлага, тоног хэрэгсэл, өвс, тэжээл, дэвсгэр, сав, баглаа боодол, чигжээс, байр, агуулах, талбай, бохирлогдсон байж болзошгүй орчны хөрс, байгууламж, бусад.

1.21.Халдварын сэжигтэй, хорио цээртэй зүйлс бүхий чингэлэг, тээврийн хэрэгслийг тусгайлан бэлтгэсэн түр тусгаарлах хэсэгт байрлуулж халдваргүйжүүлнэ.

1.22.Энэ журмын 1.13-1.20 дахь хэсгийн хэрэгжилтэд тухайн гаалийн байгууллагын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, эрүүл ахуй, стандартын хяналт хариуцсан албан тушаалтан хяналт тавьж ажиллана.

1.23.Хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй бараанд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийхдээ холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаалийн удирдах төв байгууллагаас баталсан зааврыг дагаж мөрдөнө.

1.24.Хилийн боомт болон гаалийн хяналтын бүсэд хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, хими, цацрагийн осол, хордлого зэрэг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед тухайн гаалийн байгууллагын хорио цээрийн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан мэргэжлийн байгууллагатай хамтран хариу арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

1.25.Тээвэрлэгч, мэдүүлэгч эсхүл гаалийн хяналтын бүс, баталгаат бүс эзэмшигч, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэгч нь бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах, гаалийн шалгалт хийх нөхцөлийг ажлын өдөрт багтаан бүрдүүлнэ.

1.26.Гаалийн хяналтын бүс, баталгаат бүс эзэмшигч, чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэгч нь хяналтын камерын бичлэг хийгдсэн өдрөөс хойш теле хяналтын серверт 6 сарын хугацаатай хадгалж, 12 сарын хугацаатай архивлана. Энэ хяналтын камерын бичлэгийг гаалийн хяналтын зорилгоор ашиглана.

1.27.Хяналтын камерын бичлэгийн хадгалалт, хамгаалалтад зөрчилтэй тэмцэх асуудал хариуцсан нэгж, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж, холбогдох албан тушаалтан хяналт тавьж ажиллана.

1.28.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хийх гаалийн шалгалтыг үндэслэлгүйгээр саатуулсан тохиолдолд тухайн хувь хүн, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

1.29.Хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, хяналт, шалгалтын онцлогоос шалтгаалан гаалийн хяналтын технологи ажиллагааны заавар болон ажил үүргийн хуваарийг харьяа гаалийн байгууллагын дарга энэ журам болон албан тушаалын тодорхойлолтод нийцүүлэн баталж, гаалийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлж, хяналт тавьж ажиллана.

1.30.Тээврийн төрлөөс үл хамааран тээврийн баримтад хүлээн авах буюу хүрэх гаалийн хяналтын бүсийн мэдээлэл байхгүй тохиолдолд барааны гаалийн бүрдүүлэлтийг хилийн гаалийн байгууллагад хийж дуусгана.

1.31.Гаалийн байгууллага гаалийн хяналтын төлөвөөс үл хамаарч гаалийн хилээр нэвтрүүлэх авто тээврийн хэрэгсэлд хийх шалгалтыг 1 цагт, тогтоосон цагийн хуваарьтай төмөр замын болон агаарын тээврийн хэрэгсэлд хийх шалгалтыг хуваарьт цагт багтаан хийж гүйцэтгэнэ.

1.32. Их өгөгдөлд суурилан эрсдэл тооцож, гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалтыг автоматаар хийж болно.

1.33. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн шаардлагад заасан болон энэ журамд тусгайлан заасан хугацааг мөрдөнө.

1.34. Энэ журмын хэрэгжилттэй холбоотой хүн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Хоёр. Гаалийн хилээр оруулах бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах

2.1. Бараа, тээврийн хэрэгсэл нь агаар, төмөр зам болон авто замаар тээвэрлэн улсын хилээр оруулсан үеэс хилийн гаалийн хяналтад байна.

2.2. Хилийн гаалийн байгууллага нь гаалийн хилээр оруулах бараа, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн дагалдах бичиг баримтыг гаалийн хяналтад авсан үеэс гүний гаалийн байгууллагын хяналтад оруулах хүртэлх хугацаанд хяналт тавина.

2.3. Гаалийн хилээр оруулах бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага хооронд ачааны манифестаар 3 цагийн дотор хяналтад явуулна.

2.4. Тээвэрлэгч хилийн гаалийн байгууллагаас гүний гаалийн байгууллагад хүрэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт дор тээвэрлэнэ.

2.5. Тээврийн хэрэгслийн эзэмшигч, тээвэрлэгч байгууллага улсын хилээр бараа, тээврийн хэрэгслийг оруулахаас 72 хүртэл цаг дотор цахим гарын үсэг эсвэл QR цахим тэмдгээр баталгаажсан барааны дагалдах бичиг баримт, зорчигчийн мэдээллийн хамт гаалийн байгууллагад CEPS, Gaali.mn системээр хүсэлт илгээнэ. Энэ хүсэлтэд үндэслэн хилийн гаалийн байгууллага бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад оруулна.

2.6. Гадаад улсад бүртгэлтэй автотээврийн хэрэгслийг гаалийн байгууллага CEPS системд барааны дагалдах бичиг баримт болон зорчигчийн мэдээллийн хамт бүртгэл үүсгэн 1 цагийн дотор CAIS системд оруулж, гаалийн хяналтын бүсэд нэвтрүүлнэ.

2.7. Гүний гаалийн хяналтад илгээх бараа, тээврийн хэрэгсэлд тээвэрлэгч, тээвэр зуучлалын байгууллага ачааны манифестыг CEPS систем ашиглан нөхөн бичиж, бүртгэлээс барааны дагалдах бичиг баримтыг татаж хавсарган, гаалийн байгууллагад 1 цагийн дотор цахимаар илгээнэ. Мөн шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг цахимаар оруулах боломжтой байна.

2.8.Авто замаар тээвэрлэн улсын хилээр оруулах бараа, тээврийн хэрэгслийг хилийн гаалийн байгууллага хяналтын бүсэд оруулах үед жинлэж, жингийн мэдээлэл CAIS системд автоматаар бүртгэгдэнэ.

2.9.Авто болон төмөр замаар тээвэрлэж буй ачаатай тээврийн хэрэгсэл, чингэлгийг хилийн гаалийн байгууллагын чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмжөөр шалгасан тохиолдолд тэр даруй рентген зургийг зурган файл болгон импортын ачааны манифестаад хавсарган илгээнэ.

2.10.Хилийн гаалийн байгууллага бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авахдаа тээвэрлэгч болон тээвэр зуучлалын байгууллагаас цахимаар ирүүлсэн дагалдах бичиг баримтыг системд баталгаажуулалт хийснээр гаалийн хяналтад авсанд тооцно.

2.11.Битүүмжлэлтэй тээврийн хэрэгсэлд ачсан барааг гаалийн хяналтад авахад лац, ломбо, гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг, задгай тээврийн хэрэгсэлд ачсан тохиолдолд барааны байрын тоог тээвэрлэгчээс хилийн гаалийн байгууллагад цахимаар ирүүлсэн даруй дагалдах бичиг баримттай тулган шалгана.

2.12.Энэ журмын 2.11-т заасан шалгалтаар мэдээлэл зөрсөн, гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээ гэмтсэн тохиолдолд түүнийг мэдсэн даруй тээврийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан, тэмдэглэл үйлдэж, бараа, тээврийн хэрэгслийн төрөл, онцлогоос шалтгаалан тохирох тэмдэглэгээг шинээр хэрэглэнэ.

2.13.Улсын хилээр оруулах бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээрийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагаанд энэ журмын 1.13-1.20 дахь хэсэгт заасан арга хэмжээ болон холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.14.Хилийн болон гүний гаалийн хяналтад илгээх бараа, тээврийн хэрэгсэлд хилийн гаалийн байгууллага энэ журмын 2.10-2.13-т заасан хяналтыг хэрэгжүүлж, ачааны манифестыг CAIS системд баталгаажуулснаар бараа, тээврийн хэрэгсэл нь хүрэх гаалийн байгууллагын хяналтад илгээгдэнэ.

2.15.Хилийн гаалийн хяналтын бүс хооронд бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад илгээхэд ачааны манифестаар хяналт тавина. Хүрэх хяналтын бүс хариуцсан албан тушаалтан ачааны манифест, цахим хүсэлтийг хүлээн авч баталгаажуулан 1 цагийн дотор гаалийн хяналтын бүсэд оруулна.

2.16.Тээвэрлэгч хилийн гаалийн байгууллагаас хүрэх гаалийн байгууллагын хяналтад тээвэрлэсэн барааг гаалийн хяналтын бүсэд оруулж, гаалийн хяналтын бүс эзэмшигчид 1 цагийн дотор хүлээлгэн өгнө.

2.17.Гаалийн хяналтын бүс эзэмшигч бараа, тээврийн хэрэгсэл, гаалийн тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг ачааны манифест, дагалдах бичиг баримтын мэдээлэлтэй 1 цагийн дотор тулган шалгаж, гаалийн хяналтын бүсэд оруулах хүсэлтийг CEPS системээр илгээнэ.

2.18.Гаалийн хяналтын бүс эзэмшигч нь барааны бодит мэдээлэл зөрүүтэй, гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээ гэмтсэн тохиолдолд гаалийн хяналтын бүс хариуцсан албан тушаалтанд мэдээлж, тэмдэглэлээр хүлээлгэн өгнө.

2.19.Энэ журмын 2.18-д заасан албан тушаалтан ирүүлсэн мэдээллийг нягтлан хуульд заасан арга хэмжээг авч, CAIS системд баталгаажуулснаар бараа, тээврийн хэрэгслийг гүний гаалийн байгууллагын хяналтад авсанд тооцно.

2.20.Гаалийн хяналтад байгаа бараа тээврийн хэрэгслийг зөвхөн гаалийн хяналт дор ачааны манифестаар шилжүүлнэ. Гаалийн байгууллагын хяналтын бүс хооронд шилжүүлэхэд тухайн гаалийн байгууллагад, харин гаалийн байгууллага хооронд шилжүүлэхэд тээврийн хэрэгслийн төрөл солигдох эсэхээс үл хамааран ачааны манифестын хаяг солих хүсэлтийг гаалийн удирдах төв байгууллагын хяналт, бүрдүүлэлтийн асуудал хариуцсан нэгжид гаргаж шийдвэрлүүлнэ.

2.21.Гаалийн хяналтын бүс дэх гаалийн хяналтад байгаа барааг гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсэд оруулах тохиолдолд гаалийн бүрдүүлэлтийн горим сонгоно.

Гурав. Гаалийн хилээр оруулах бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийх

3.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтын бүсэд Гаалийн тухай хуульд зааснаар 3 хоног хүртэл хугацаагаар хадгалж болох бөгөөд энэ хугацаанд мэдүүлэгч гаалийн бүрдүүлэлтийн горим сонгоогүй бол гаалийн түр агуулахад шилжүүлнэ.

3.2.Гаалийн түр агуулахад оруулах боломжгүй бол гаалийн нээлттэй түр агуулахад шилжсэнд тооцож, гаалийн хяналтын бүсэд хадгална.

3.3.Хадгалалт, тээвэрлэлтийн онцгой нөхцөл шаардах барааг зориулалтын агуулах, байгууламжид хадгалах бөгөөд тухайн гаалийн хяналтын бүс нь зориулалтын агуулахгүй тохиолдолд Гаалийн тухай хуульд заасан шаардлага хангасан мэдүүлэгчийн агуулахад, татварын баталгаа гаргуулан битүүмжлэн хадгалуулж болно.

3.4.Мэдүүлэгч барааг мэдүүлэхэд гаалийн удирдах төв байгууллагын даргын баталсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар”, гаалийн байгууллага гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтыг хүлээн авч, шалгахад “Гаалийн

хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар”-ыг дагаж мөрдөнө.

3.5.Мэдүүлэгч гаалийн байгууллагад барааг CEPS болон Gaali.mn систем ашиглан мэдүүлэхэд CAIS системээс тухайн бараанд шалгалт хийх “Улаан”, “Улбар шар”, “Ногоон” хяналтын төлөв илэрхийлэгдэж, шалгалт хийх албан тушаалтан санамсаргүй сонголтоор автоматаар томилогдоно.

3.5.1.Гаалийн хяналтын “Ногоон” төлөв сонгогдсон тохиолдолд гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлөх;

3.5.2.Гаалийн хяналтын “Улбар шар” төлөв сонгогдсон тохиолдолд гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтад шалгалт хийж, барааг шалгалтаас чөлөөлөх;

3.5.3.Гаалийн хяналтын “Улаан” төлөв сонгогдсон тохиолдолд гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримт, бараа, тээврийн хэрэгсэлд шалгалт хийх.

3.6.Энэ журмын 1.9-д заасан мэдээллийг үндэслэн “Ногоон”, “Улбар шар төлөв”-т сонгогдсон гаалийн мэдүүлэгт шалгалт хийж болно. Энэ тохиолдолд хяналт, шалгалт хийх гаалийн улсын байцаагч CAIS системээс санамсаргүй сонголтоор автоматаар томилогдоно.

3.7.Энэ журмын 1.9, 3.6-д заасан үндэслэлээр барааг шалгаж шийдвэрлэсэн тохиолдолд CAIS системийн гаалийн мэдүүлгийн “Мэдээлэл” талбарт шийдвэрийн үндэслэл, шалтгаан, шалгалтын үр дүнг 1 цагийн дотор бичиж оруулна.

3.8.Мэдүүлсэн бараанд гаалийн болон бусад татвар, хураамжийн нэхэмжлэх дараах байдлаар үүснэ:

3.8.1.гаалийн хяналтын “Ногоон” төлөв сонгогдсон мэдүүлэгт автоматаар;

3.8.2.гаалийн хяналтын “Улбар шар” болон “Улаан” төлөв сонгогдсон мэдүүлэгт гаалийн байгууллага бичиг баримтын шалгалт хийж дууссанаар;

3.9.Мэдүүлэгч татвар, хураамжийг төлснөөр гаалийн мэдүүлэг “Ногоон”, “Улбар шар” төлөвт сонгогдсон тохиолдолд автоматаар, “Улаан” төлөвт сонгогдсон тохиолдолд бараанд шалгалт хийж, зөрчил илрээгүй бол тус тус хүчин төгөлдөр болж, барааг эзэнд нь олгоно.

3.10.Гаалийн мэдүүлэг хүчин төгөлдөр болсноор мэдүүлэгч нь тухайн гаалийн мэдүүлгийг Gaali.mn системээс хэвлэн авах боломж бүрдэнэ.

3.11.Гаалийн зөрчилтэй тэмцэх асуудал хариуцсан нэгжээс гэмт хэргийн шинжтэй, худалдааны луйвар, барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоотой үндэслэл бүхий мэдээлэл ирүүлсэн

тохиолдолд татвар төлсөн буюу түүнээс хойших үе шатанд тус нэгжийн дарга хамтарсан хяналт шалгалт хийх үндэслэл, шалтгааныг CAIS системд оруулан баталгаажуулмагц хамтран шалгалт хийх албан тушаалтан CAIS системээс санамсаргүй сонголтоор автоматаар томилогдоно.

3.12.Бараа, тээврийн хэрэгсэлд хийсэн шалгалтын үр дүнг CAIS системд 1 цагийн дотор оруулна. Энэ журмын 1.9, 3.11 дэх хэсэгт заасан мэдээллийн дагуу зохион байгуулсан гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар баталсан зааврын дагуу дуу авиа, дүрс бичлэгээр баталгаажуулна.

3.13.Бараа, тээврийн хэрэгсэлд хийх гаалийн шалгалтыг ажлын өдөрт, ажлын цагт багтаан дуусгана. Хэрэв тухайн өдрийн ажлын цагт хяналт шалгалтыг бүрэн хийж дуусгах боломжгүй тохиолдолд удирдах албан тушаалтанд мэдэгдэж, шийдвэрлүүлнэ.

3.14.Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах үйл ажиллагаанд гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар батлагдсан холбогдох журмыг дагаж мөрдөнө.

3.15.Магадлан шинжилгээнд хамруулах шаардлагатай барааг гаалийн хяналтын төлөвийг харгалзан хамруулна. Магадлан шинжилгээний дүгнэлтийг гаалийн мэдүүлэгт тусгана.

3.16.Магадлан шинжилгээнд хамруулах шаардлагатай бараа гаалийн хяналтын “Улаан” төлөвт сонгогдсон тохиолдолд магадлан шинжилгээний дүгнэлтийг үндэслэн бичиг баримтын шалгалтыг 3 хүртэл цагийн дотор хийж гүйцэтгэнэ.

3.17.Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны дагалдах бичиг баримтаас барааны нэр, ангиллын код зөрүүтэй, мэргэжлийн тусгай мэдлэг шаардагдах, тээвэрлэлт, хадгалалтын горим зөрчсөн, гэмтэж, муудсан, битүүмжлэл алдагдсан барааг гаалийн хяналтын төлөв харгалзахгүй нэн даруй магадлан шинжилгээнд хамруулна.

3.18.Бараа гаалийн хяналтад байх хугацаанд тоо хэмжээ нь дутсан, жин нь багассан, гэмтсэн, чанараа алдсан, зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь гаалийн шалгалтаар илэрсэн тохиолдолд уг барааг гаалийн хяналтад байх хугацаанд МҮХАҮТ болон бусад эрх бүхий байгууллагаас цахимаар ирүүлсэн магадлагаа, дүгнэлтийг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ.

3.19.Гаалийн хяналт, шалгалт, бүрдүүлэлтийн явцад зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3.20.Гаалийн хяналт, шалгалтаар барааны нэр, төрөл, марк, үзүүлэлт, тоо хэмжээ, барааны ангиллын кодыг буруу мэдүүлсэн, эсхүл гаальд мэдүүлээгүй бараа илэрсэн тохиолдолд өмнөх гаалийн

мэдүүлгийг хэвлэн, зөрчлийн нотлох бичиг баримт болгох бөгөөд зөрчилд холбогдсон барааны гаалийн мэдүүлгийг шинээр нөхөн мэдүүлж, гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.

3.21.Гаалийн бүрдүүлэлт хийгдэж дууссаны дараа гаалийн хяналтын бүс эзэмшигч нь барааг гаалийн хяналтын бүсээс гаргах хүсэлтийг гаалийн байгууллагад 1 цагийн дотор цахимаар илгээж зөвшөөрөл авна.

Дөрөв. Гаалийн хилээр гаргах бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийх

4.1.Монгол Улсын хилээр гаргах барааг гаалийн байгууллагад хүсэлт гарган гаалийн хяналтын бүсэд оруулна. Бараа, тээврийн хэрэгсэл гаалийн хяналтын бүсэд орсон үеэс хилээр гарах хүртэлх хугацаанд гаалийн хяналтад байна.

4.2.Гаалийн байгууллага гаалийн хилээр гаргах барааг энэ журмын 1.13-т заасны дагуу мэдүүлэгчийн зардлаар мэдүүлэгчийн байр, агуулах, талбай, байгууламжид гаалийн хяналт, шалгалтыг ажлын өдөр ажлын цагт багтаан гүйцэтгэнэ.

4.3.Улсын хилээр гаргах бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.4.Мэдүүлэгч хилээр гаргах барааны хүсэлтийг дагалдах бичиг баримтын хамт хавсарган CEPS болон Gaali.mn системээр илгээх бөгөөд гаалийн байгууллага 1 цагийн дотор CAIS системд хянан баталгаажуулна.

4.5.Гаалийн хилээр гаргах бараа, тээврийн хэрэгслийг энэ журмын 3.4-3.22-д заасны дагуу шалгаж, хууль тогтоомжийн дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

4.6.Гаалийн хилээр гаргах барааг гаалийн байгууллага, гаалийн хяналтын бүс хооронд гаалийн мэдүүлгээр хяналтад илгээж, тээвэрлэгч байгууллага барааг гаалийн хяналт дор тээвэрлэнэ.

4.7.Бараа, тээврийн хэрэгслийн онцлогоос шалтгаалан гаалийн зорилгоор хийх тэмдэглэгээний аль тохирохыг сонгон хэрэглэж, CAIS системд 1 цагийн дотор бүртгэнэ.

4.8.Гүний гаалийн байгууллагын бүрдүүлэлтийг CAIS системд баталгаажуулснаар хилээр гарах тээврийн хэрэгслийн бүртгэл автоматаар үүсэж, хилийн гаалийн байгууллагад цахимаар илгээгдэнэ.

4.9.Хилийн гаалийн байгууллага экспортын гаалийн мэдүүлгийг үндэслэн бараа, тээврийн хэрэгслийг хилийн гаалийн хяналтын бүсэд очмогц нэн даруй оруулна.

4.10.Барааг битүүмжлэлтэй тээврийн хэрэгсэл, чингэлэгт ачсан тохиолдолд лац, ломбо, гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг,

задгай тээврийн хэрэгсэлд ачсан тохиолдолд барааны байрын тоо, бусад бүрэн бүтэн байдлыг тээвэрлэгчээс цахимаар ирүүлсэн дагалдах бичиг баримттай тулган шалгаж хилийн гаалийн хяналтад авна. Зөрчилгүй тохиолдолд гаалийн мэдүүлгийг CAIS системд 30 минутын дотор баталгаажуулж хүчин төгөлдөр болгоно.

4.11.Гаалийн байгууллагад мэдүүлж, гаалийн хяналтын бүсэд оруулсан бараа, тээврийн хэрэгслийг шалгах явцад мэдүүлэгчийн хүсэлтээр гаалийн хяналтын бүсээс буцаан гаргахгүй. Шалгалтаар гаалийн хууль тогтоомж зөрчсөн зөрчил илрээгүй тохиолдолд мэдүүлэгчийн гаргасан хүсэлтэд үндэслэн хяналтын бүсээс буцаан гаргаж болно.

4.12.Гаалийн хяналт, шалгалтын явцад гаалийн болон бусад хууль тогтоомж зөрчсөн үйлдэл илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэж, тухайн барааг мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулна.

4.13.Гаалийн хилээр гаргах бараа, тээврийн хэрэгслийг хилийн гаалийн байгууллагад анх мэдүүлсэн тохиолдолд гаалийн бүрдүүлэлтийг энэ журмын 4.5-д заасны дагуу хилийн гаалийн байгууллага хийж гүйцэтгэнэ.

4.14.Хоосон чингэлгийг хилийн чанадад гаргах хүсэлтийг үндэслэн гүний гаалийн байгууллага хяналт тавьж, 1 цагийн дотор хилийн гаалийн байгууллагын хяналтад илгээнэ. Үүнд:

4.14.1.Төмөр замаар тээвэрлэгдэх хоосон чингэлэгт лац, ломбо тавьж;

4.14.2.Авто замаар тээвэрлэгдэх хоосон чингэлэгт лац, ломбогүйгээр.

4.15.Хилийн гаалийн байгууллага гүний гаалийн байгууллагаас илгээсэн хоосон чингэлгийг эсхүл гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг шалгаж, зөрчилгүй тохиолдолд тэр даруй хилээр гаргах зөвшөөрлийг олгоно.

4.16.Хэрэв гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээ гэмтсэн, мэдээлэл зөрсөн, зөрчил илэрсэн тохиолдолд нэн даруй тээврийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан тэмдэглэл үйлдэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Тав. Дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих

5.1.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр оруулах болон гаргахад хяналт тавих хилийн гаалийн байгууллага тээврийн баримтаар гаалийн хяналтад авч, ачааны манифестаар хяналт тавина.

5.2.Тээвэрлэгч, тээвэр зуучлалын байгууллага нь агаар, авто, төмөр замын тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн дагалдах бичиг баримтыг үндэслэн ачааны манифестыг нэн даруй нөхөн бичиж, гаалийн байгууллагад илгээнэ.

5.3.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн хяналтад авсан гаалийн байгууллага “Гаалийн хяналтад байгаа”, гаалийн хяналтаас гаргаж байгаа гаалийн байгууллага “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдгийг тээврийн үндсэн бичиг баримтын зөвхөн эх хувьд дарж, хувийн дугаар бүхий тэмдгээр баталгаажуулан тээвэрлэгчид шилжүүлэн гаалийн хяналтад илгээнэ. Цахимаар ирүүлсэн тохиолдолд тэр даруй тээвэрлэгчийн тухайн систем рүү баталгаажуулж цахимаар мэдээллийг солилцоно.

5.4.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх барааны ачааны манифестыг нөхөн бичих, хянахад “Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам”-ыг дагаж мөрдөнө.

5.5.Гаалийн байгууллага нь дамжуулан өнгөрүүлэх бараанд илгээгч улсын гаалийн байгууллагын тавьсан гаалийн тэмдэглэгээг хүлээн зөвшөөрч болно.

5.6.Дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгсэл солих үйл ажиллагааг гаалийн хяналт дор гүйцэтгэнэ.

5.7.Шаардлагатай тохиолдолд барааг гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхэд тухайн бараа, тээврийн хэрэгслийг хилийн гаалийн байгууллагын хяналтад орсон үеэс гаалийн хилээр буцаан гаргах хүртэлх хугацаанд гаалийн улсын байцаагчийг дагалдуулж болно.

5.8.Дамжуулан өнгөрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн дагалдах бичиг баримт нь хилийн гаалийн нэг байгууллага хяналтад авсан үеэс нөгөө хилийн гаалийн байгууллагын хяналтад оруулах хүртэлх хугацаанд эхний бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллагын хяналтад байна.

5.9.Шилжүүлэн ачих бараа, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн дагалдах бичиг баримт нь барааг шилжүүлэн ачих хилийн гаалийн байгууллагын хяналтад байна.

5.10.Дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага дараах тохиолдолд шалгана:

5.10.1.гаалийн битүүмжлэл гэмтсэн, эсхүл алдагдсан;

5.10.2.гаалийн байгууллагад бараа, тээврийн хэрэгслийг нягтлан шалгах тодорхой үндэслэл байгаа.

5.11.Дамжуулан өнгөрүүлэх, шилжүүлэн ачих бараа, тээврийн хэрэгслийг шалгахдаа тээвэрлэгч, зуучлагч байгууллагын төлөөлөгчийг оролцуулах ба шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагаас төлөөлөгч байлцуулна.

5.12.Дотоодод дамжуулан өнгөрүүлэх бараанд Гаалийн тухай хууль, энэ журам болон “Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам”-ын холбогдох заалтын дагуу гаалийн хяналт тавина.

5.13.Уул уурхайн эрдэс, бүтээгдэхүүнийг нэг гаалийн хяналтын бүсээс нөгөө гаалийн хяналтын бүсийн хооронд дотоодод дамжуулан өнгөрүүлэх тохиолдолд ачааны манифестаар хяналт тавина.

5.14.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

5.15.Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэх мэдэгдэл, олон улсын мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн гэрчилгээ, дагалдах бичиг баримт, гаалийн зорилгоор хийсэн тэмдэглэгээг нэн даруй шалгаж, зөрчилгүй тохиолдолд улсын хилээр нэвтрүүлнэ.

Зургаа. Бусад

6.1.Гаалийн байгууллага хооронд бараа, тээврийн хэрэгслийг хяналтад илгээхэд гаалийн удирдах төв байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэнэ.

6.2.Барааг гаалийн хяналтын төлөвийн дагуу шалгалтаас чөлөөлсөн бол гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулж, гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлсэн эсэхийг нягтлан шалгаж болно.

6.3.Бараа гаалийн хяналтад байх хугацаанд гэмтэж муудсан, чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй болсон, эрүүл ахуй, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй болох нь мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн барааг нэн даруй хилийн чанадад буцаан гаргах, буцаах боломжгүй бол бараа устгах горимыг хэрэгжүүлэх журмын дагуу устгана.

6.4.Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд албан тушаалын тодорхойлолт болон чиг үүргийн дагуу оролцсон, зөвшөөрөл олгосон, баталгаажуулсан гаалийн албан тушаалтан түүнээс үүсэн гарах эрх зүйн үр дагавар, хариуцлагыг бүрэн хариуцна.

6.5.Гаалийн удирдах төв байгууллагын харьяа гаалийн байгууллага нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах гаалийн

баталгаат бүс, хяналтын бүсэд хяналт тавьж ажиллана.

6.6.Энэ журмаар зохицуулагдаагүй харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.7.Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийхдээ энэхүү журмыг дагаж мөрдөөгүй албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 7348 дугаарт бүртгэв.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 6/09

Даланзадгад хот

БИЧИЛ УУРХАЙН ЗОРИУЛАЛТААР ГАЗАР НУТГИЙГ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11, 16.2, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутаг дэвсгэрт орших “Даянгар үзүүр овоо -7” нэртэй солбицол бүхий 4,91 га /гектар/, “Даянгар үзүүр овоо -8” нэртэй солбицол бүхий 4,91 га /гектар/, “Даянгар үзүүр овоо -9” нэртэй солбицол бүхий 4,98 га /гектар/ газрыг тус тус бичил уурхайн зориулалтаар 5 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хэрэгцээнд авсугай.

2.Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын талбайн солбицлыг нэгдүгээр, дэвсгэр зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тогтоолыг хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэн бүртгүүлж, орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА


О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

**Цогт-Овоо сумын “Даянгар үзүүр овоо-7,8,9” нэртэй бичил
уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах
газрын солбицол**

Даянгар үзүүр овоо-7 нэртэй 4.91 гектар талбай		
№	Уртраг	Өргөрөг
1	105°36'47.5"	44°25'7.6"
2	105°36'56.44"	44°25'6.81"
3	105°36'59.15"	44°24'59.18"
4	105°36'53.00"	44°24'57.00"
Даянгар үзүүр овоо-8 нэртэй 4.91 гектар талбай		
№	Уртраг	Өргөрөг
1	105°36'56.6"E	44°25'5.35"N
2	105°37'2.77"E	44°25'5.92"N
3	105°37'14.52"E	44°25'5.91"N
4	105°37'14.95"E	44°25'3.11"N
5	105°37'5.63"E	44°25'1.93"N
Даянгар үзүүр овоо-9 нэртэй 4.98 гектар талбай		
№	Уртраг	Өргөрөг
1	105°35'41.75"E	44°25'17.34"N
2	105°35'59.66"E	44°25'17.87"N
3	105°35'55.5"E	44°25'13.74"N
4	105°35'41.38"E	44°25'12.48"N
5	105°35'40.37"E	44°25'15.89"N

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/09 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 6/10

Даланзадгад хот

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭРИЙН ЗОРИУЛАЛТААР ГАЗАР НУТГИЙГ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6, 16.2, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Найз, Бортээг багийн нутагт орших аймаг, сум дундын отрын бүс нутаг болох “Цохио” орчмын 139023,58 га /гектар/ газрыг аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар 5 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хэрэгцээнд авсугай.

2.Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын эргэлтийн цэгийн солбицлыг нэгдүгээр, талбайн зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тогтоолыг хуулийн хугацаанд холбогдох газарт нь хүргүүлэн бүртгүүлж, орон нутгийн тусгай хэрэгцээнд авч хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА


О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ЦОГТ-ОВОО СУМЫН НАЙЗ, БОРТЭЭГ БАГИЙН НУТАГ ДАХЬ
“ЦОХИО” НЭРТЭЙ 139023,58 ГА /ГЕКТАР/ АЙМАГ ДУНДЫН
БЭЛЧЭЭРИЙН ЗОРИУЛАЛТААР ОРОН НУТГИЙН ТУСГАЙ
ХЭРЭГЦЭЭНД АВАХ ГАЗРЫН СОЛБИЦОЛ**

№	Уртраг	Өргөрөг
1	104°32'46.32"E	44°15'4.97"N
2	104°39'18.24"E	44°13'30.31"N
3	104°42'38.57"E	44°17'14.08"N
4	104°48'2.93"E	44°19'4.55"N
5	104°58'47.95"E	44°19'15.44"N
6	104°58'52.75"E	44°18'3.43"N
7	105° 8'54.54"E	44°17'49.34"N
8	105°19'20.58"E	44°19'0.10"N
9	105°19'27.43"E	44°10'52.98"N
10	105° 8'10.39"E	44° 9'32.01"N
11	105° 6'39.66"E	44° 7'52.64"N
12	105°11'33.50"E	44° 0'22.89"N
13	105°11'14.21"E	43°58'50.28"N
14	105° 6'57.67"E	43°58'47.22"N
15	105° 2'45.97"E	44° 1'14.88"N
16	104°52'18.41"E	44° 1'42.11"N
17	104°52'3.62"E	44° 5'49.07"N
18	104°43'31.24"E	44° 6'11.79"N
19	104°43'28.60"E	44° 8'44.15"N
20	104°30'15.56"E	44°13'25.14"N

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 7350 дугаарт бүртгэв.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 6/11

Даланзадгад хот

ЗАРИМ ГАЗАР НУТГИЙГ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Байгаль орчны сайдын 2000 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 07 тоот тушаалаар батлагдсан “Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай” журмыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Цогт-Овоо сумын Бортээг багийн нутаг дахь “Цогт хайрхан” нэртэй уламжлалт зан үйлтэй холбоотой, тахилгат овоо хайрхан бүхий түүх соёлын дурсгалт 39425,74 га /гектар/ газрыг 15 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.

2.Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын эргэлтийн цэгийн солбицлыг нэгдүгээр, дэвсгэр зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Энэхүү тогтоолыг хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэн бүртгүүлж, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА


О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/11 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ЦОГТ-ОВОО СУМЫН БОРТЭЭГ БАГИЙН НУТАГ ДАХЬ “ЦОГТ
ХАЙРХАН” НЭРТЭЙ 39425,74 ГА /ГЕКТАР/ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТАД АВСАН ГАЗРЫН СОЛБИЦОЛ**

№	Уртраг	Өргөрөг
1	105°22'29.50"E	44°18'30.84"N
2	105°40'48.22"E	44°18'34.36"N
3	105°48'1.26"E	44°15'1.43"N
4	105°41'7.11"E	44°11'25.45"N
5	105°22'38.76"E	44°11'34.91"N

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/11 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт**



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 8 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 6/12

Даланзадгад хот

ЗАРИМ ГАЗАР НУТГИЙГ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Байгаль орчны сайдын 2000 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 07 тоот тушаалаар батлагдсан “Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай” журмыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Цогт-Овоо сумын Замыншанд багийн нутаг дахь “Баянгийн хоолой” нэртэй 26323.27 га /гектар/ байгалийн унаган төрхөө хадгалсан, байгалийн өвөрмөц тогтоц бүхий дурсгалт газрыг 15 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.

2.Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын эргэлтийн цэгийн солбицлыг нэгдүгээр, дэвсгэр зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Энэхүү тогтоолыг хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэн бүртгүүлж, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА


О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/12 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**ЦОГТ-ОВОО СУМЫН ЗАМЫНШАНД БАГИЙН НУТАГ ДАХЬ
“БАЯНГИЙН ХООЛОЙ” НЭРТЭЙ 26323.27 ГА /ГЕКТАР/ ОРОН
НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВСАН ГАЗРЫН СОЛБИЦОЛ**

№	Уртраг	Өргөрөг
1	105°17'58.843"E	44°29'25.508"N
2	105°17'43.599"E	44°24'45.545"N
3	104°51'40.622"E	44°25'56.173"N
4	104°51'43.633"E	44°29'25.018"N

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн
6/12 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авсан.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 299

Улаанбаатар
хот

“ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ыг 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 8 дугаар
сарын 25-ны өдөр

ДугаарА/44

Улаанбаатар
хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Загвар батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/343 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийн загвар”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүйн туслалцааны төвийн захирал (Л.Уянга)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Загвар батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/343 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.МӨНХБААТАР

*Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 8 дугаар сарын 25-ны
өдрийн А/44 дүгээр тушаалын хавсралт*



УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИЙН ШИЙДВЭР

... оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Дугаар ...

.....
хот, аймаг, сум

Хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах тухай

Хууль зүйн туслалцааны төвийн дахь салбарын
улсын өмгөөлөгч
.. (албан тушаал, овог, нэр) би,
.. (хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээд)-ээс ... оны ... дугаар сарын-
ний өдөр гаргасан
.....(товч утга) гэх
хүсэлттэй танилцаад ОЛСОН нь:

.....
.....
.....

(хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг бичих) үндэслэлээр
хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэлтэй байх тул

- ☐ Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг;
- ☐ Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг;
- ☐ Хууль зүйн туслалцаа үзүүлэх журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг;

-т заасныг удирдлага болгон ШИЙДВЭРЛЭХ нь:

1.Илэрсэн нөхцөл байдлыг үндэслэн иргэн-
д өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсугай.

2.Энэ талаар хүсэлт гаргагч-д мэдэгдэж, шийдвэрийн хувийг бичгээр, цахимаар (доогуур нь зурах) хүргүүлсүгэй.

3.Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор Хууль зүйн туслалцааны төвд гомдол гаргаж болохыг дурдсугай.

УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧ
(гарын үсэг, тэмдэг) (овог, нэр)